



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025. 04. 28 № 01/301
танай _____-ны № _____-т

**ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Батсүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор “Монгол ардын нам”-ын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Батсүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцохоор “Монгол ардын нам”-аас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн

412502292

бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Монгол ардын нам”-ын мөрийн хөтөлбөр (... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Батсүмбэр сумын Сонгуулийн хороонд

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.04.22 № 01/303
танай _____-ны № _____-т

Г Хандивын тайлангийн дүгнэлт Г

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Батсүмбэр сумын “Монгол ардын нам”-аас ирүүлсэн хандивын тайланг Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Төв аймаг дахь Төрийн аудитын газар хянан баталгаажуулж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Батсүмбэр сумын “Монгол ардын нам” нь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай” хуулийн 37 дугаар зүйлийн 37.8-д заасны дагуу Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлж, дүгнэлт гаргуулах үүргийг хүлээнэ.

Хандивыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 16 дугаар зүйл, Сангийн сайдын 2017 оны 386 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн бус байгууллагын санхүүгийн тайлангийн маягт, заавар”-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайландаа тусгах үүргийг улс төрийн нам хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1-д заасны дагуу сумын нөхөн сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэлд иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг хянан баталгаажуулж, дүгнэлт гаргана.

Нам, эвслээс дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн хандивын тайланд тусгагдаагүй хандивыг хянан баталгаажуулахгүй бөгөөд түүнээс үүсэх үр дагавар, хариуцлагыг Төв аймаг дахь Төрийн аудитын газар хүлээхгүй болно.

Дүгнэлтийн үндэслэл

Төв аймаг дахь Төрийн аудитын газар нь Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Батсүмбэр сумын “Монгол ардын нам”-д иргэн, хуулийн этгээдээс өгсөн хандивын тайланг Төрийн Аудитын стандарт MNS 6817:2020, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны А/49 дугаар тушаалаар батлагдсан зааврыг баримтлан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай” хуулийн 55 дугаар зүйл, Улс төрийн намын тухай хуулийн 34 дүгээр зүйлтэй тус тус нийцэж буй эсэхийг дэмжих нотлох баримт, дүн дүгнэлтийн үндсэн дээр хянан баталгаажуулж, дүгнэлт гаргасан болно.

Дүгнэлт

Батсүмбэр сумын “Монгол ардын нам” нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал хураасан өдрөөс хойш нөхөн сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд хандив хүлээн аваагүй, хандивын орлого бүртгэгдэж тайлагнаагүй байна.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

412502297



**ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН
МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО**

**ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС
2025 ОНЫ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД
ДЭВШҮҮЛЭН ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

БАТСҮМБЭР

АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1. Боловсрол
- 1.2. Эрүүл мэнд
- 1.3. Соёл
- 1.4. Спорт
- 1.5. Хөдөлмөр эрхлэлт
- 1.6. Орон сууцжуулах бодлого
- 1.7. Хүн ам, нийгмийн бүлэг бүрд чиглэсэн хөгжлийн бодлого

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

- 2.1. Эдийн засаг, төсөв санхүү
- 2.2. Олон тулгуурт эдийн засаг ба гадаад харилцаа

ГУРАВ. ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 3.1. Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил
- 3.2. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт- Шинэ хоршоо хөдөлгөөн
- 3.3. Нийлүүлэгчийн зэрэгцээ үйлдвэрлэгч аймаг

ДӨРӨВ. НОГООН ЭДИЙН ЗАСАГ БА АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГО

- 4.1 Төрөлжсөн аялал жуулчлал
- 4.2 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл

ТАВ. БАЙГАЛЬ ОРЧИН - НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 5.1 Хүрээлэн буй орчин ба ногоон хөгжил
- 5.2 Үнэт баялаг ус, ой

ЗУРГАА. ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРТ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 6.1 Хөгжлийг тэтгэсэн дэд бүтэц-Сумын хөгжил
- 6.2 Зам дагасан хөгжил / Хөгжлийн зам, Хөгжил дагуулсан зам, Нутгийн зам/

ДОЛОО. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАГЛАЛ

- 7.1 Хүний эрх ба амар тайван аюулгүй орчин
- 7.2 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
- 7.3 Цахим засаглал ба иргэдэд ойр төрийн үйлчилгээ

НАЙМ. ОРОН НУТАГ, БАГ

- 8.1 Шинэ зууны шинэ төрх- Батсүмбэр сум
- 8.2 Шинэ Батсүмбэр сум -бүтээн байгуулалт

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛӨЛ

1.1 Боловсрол

- 1.1.1 **"Оюунлаг Батсүмбэрчүүд"** хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлж, бүх шатны боловсролын сургалтын чанар, хүртээмжийг сайжруулна.
- 1.1.2 **"Хүүхэд бүр цэцэрлэгт"** хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлж, бүлэг дүүргэлтийг стандартын түвшинд байлгаж, сургуулийн өмнөх боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
- 1.1.3 5 настай хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулж, сургуульд бэлтгэхэд онцгойлон анхаарна.
- 1.1.4 Суралцагчдад ээлтэй, сурч хөгжихөд таатай орчин бүрдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг төлөвлөн хэрэгжүүлнэ.
- 1.1.5 Тусгай хэрэгцээт хүүхдийн сурах боломж нөхцлийг сайжруулж, хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулна.
- 1.1.6 **"Хөгжсөн багшаас-Чадварлаг сурагч"** хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, багш нарын ажлын байрандаа сурч хөгжих нөхцөлийг бүрдүүлэн, гадаад, дотоодод сурах, туршлага судлах үйл ажиллагаанд үе шаттай хамруулна.
- 1.1.7 Боловсролын салбарын хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.
- 1.1.8 Бүх шатны боловсролын байгууллагуудад орчин үеийн мэдээлэл, харилцаа холбооны технологи, цахим системд тулгуурласан цахим анги танхимыг байгуулна..
- 1.1.9 Сургуулиудын "Үдийн хоол" хөтөлбөрийн үйлчилгээний менежментийг боловсронгуй болгоно.
- 1.1.10 **"Хүүхэд бүрд сүү"** хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.
- 1.1.11 **"Төв +100"** хөтөлбөр хэрэгжүүлж, гадаад, дотоодын шилдэг их сургуульд тэтгэлгээр сурах оюутны тоог нэмэгдүүлнэ.
- 1.1.12 Хувийн хэвшлийн боловсрол, сургалтын байгууллагын үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.

1.1.13 Бүх шатны боловсролын байгууллагад “Хүүхэд хангад”-ийн “Эрх”-ыг хэрэгжүүлж, цэцэрлэг, сургуулийн орчныг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах орчныг бүрдүүлнэ.

1.1.14 “Хүүхдэд ээлтэй дотуур байр” хөтөлбөрийг үргэлжлүүлж, үйлчилгээний чанар стандартыг мөрдүүлэх, сэтгэл зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглүүлнэ.

1.1.15 Хүүхдэд Монгол ёс заншлаа дээдэлсэн, зөв төлөвшил хандлагатай, эх оронч, эрх чөлөөт сэтгэлгээтэй, үндэсний бахархлыг төлөвшүүлж, “Хүүхэд - Эрдэнэ” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.16 Хүүхдэд багачуудыг амьдрах арга ухаанд сургах, хөдөлмөрт бэлтгэх зорилгоор байгуулагдсан “Хүүхдийн хөдөлмөр зуслан” –уудын үйл ажиллагааг өргөжүүлж, тогтмол ажиллуулна.

1.1.17 Ажил хөдөлмөр эрхлэх, өрхийн орлогоо нэмэгжүүлэх, шинэ шинэлэг мэдээлэл технологи ашиглах, нийгэмдээ дасан зохицох, эрүүл саруул зөв амьдрахад чиглүүлсэн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.

1.2 Эрүүл мэнд

1.2.1 Хүн амыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлж, өвчнийг эрт илрүүлэх бодлого хэрэгжүүлж, иргэн бүрийг 46 жил тутамд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулна.

1.2.2 Хавдрын эсрэг “Эрүүл Батсүмбэрчүүд” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхэд холбогдуулан сумын иргэдээ үзлэгт хамруулна.

1.2.3 Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, “Эрүүл эцэг эхээс эрүүл хүүхэд” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн сумын иргэдээ хамруулна.

1.2.4 Хүүхдийн шүдний урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, суманд шүдний тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэн “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийг үргэлжлүүлнэ.

1.2.5 Эрүүл мэндийн төвийн хүний нөөцийн хангалт, ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.

1.2.6 Эмч, сувилагч, эрүүл мэндийн ажилтнуудыг гадаад харилцаа, хамтын ажиллагаатай улсад сургаж, дадлагажуулна.

1.2.7 Эмийн төлөвлөлт, худалдан авалт, хангамжийг стандартын дагуу зохион байгуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг бүрэн хангуулна.

1.2.8 Эрүүл мэндийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлнэ.

1.3 Соёл

1.3.1 Соёлын биет болон биет бус өвийг судлах, бүртгэлжүүлэх, хадгалах, хамгаалах, олон нийтэд таниулах, сэргээн хөгжүүлэх, өвлүүлэн уламжлуулах арга хэмжээг олон хэлбэрээр зохион байгуулна.

1.3.2 Орон нутгийн онцлог бүхий уламжлалт өв соёл, шилдэг бүтээлүүдийг олны хүртээл болгох, шинэ уран бүтээл туурвихад соёл урлагийн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлнэ.

- 1.3.3 Иргэдэд зориулсан соёл, урлагийн үзвэр үйлчилгээний чанарыг сайжруулж, тэдний санал санаачилга, хүсэл сонирхолд нийцсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хүртээмжтэй зохион байгуулна.
- 1.3.4 Түүх соёлын дурсгал, урлагийн бүтээл, утга зохиолиор дамжуулан хүүхэд, залуучуудад үндэсний үнэт зүйл, эх хэл, бичиг соёлоороо бахархаж, дээдлэх үзэл санаа, мэдлэг чадвар олгоно.
- 1.3.5 Үндэсний гар урлаачид, уран зураачид, уран дархчуул, уран барималчид, хувцас урлаачид болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллана.
- 1.3.6 Эрдэмтдийн зөвлөлтэй хамтран түүхэн дурсгалт газрууд, археологи, палеонтологи, угсаатны зүйн чиглэлээр судалгаа хийж, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 1.3.7 Сумын соёлын төвийг орчин үеийн шаардлага хангасан техник тоног төхөөрөмжөөр хангаж, соёл урлаг, сургалт мэдээллийн төв болгоно.
- 1.3.8 Соёлын салбарын мэргэжилтгүүдийг бэлтгэх, давтан сургахад гадаад дотоодын их дээд сургууль, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

1.4 Спорт

- 1.4.1 Сумандаа нийтийн биеийн тамирын талбай, спорт залуудын гүйцэтгэлийн ажлыг бүрэн дуусгаж тогтнол ажиллуулна.
- 1.4.2 Иргэдэд эрүүл идэвхтэй амьдралын дадал, хэвшил төлөвшүүлэх, дэд бүтэц, орчинг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бий болгоно.
- 1.4.3 Сумын өсвөр үе, залуучуудын шигшээ багийн тамирчдын бэлтгэл сургуулилтыг сайжруулж, тив, дэлхий, олимпод өрсөлдөх амжилтад хүргэх зорилт тавьж ажиллана.
- 1.4.4 Орон нутгийн онцлог давуу талд түшиглэсэн үндэсний бөх, морин уралдаан, шагайн харваа зэрэг үндэсний спортын төрлүүдэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэн хөгжүүлнэ.
- 1.4.5 Улс, аймгийн болон олон улсын чанартай спортын тэмцээн, уралдааныг сумандаа зохион байгуулна.
- 1.4.6 Улсын аварга шалгаруулах болон тив, дэлхийн тэмцээн уралдаанд сум, аймгаа төлөөлөн оролцох тамирчдад дэмжлэг тусалцаа үзүүлж тусгай бэлтгэлд хамруулна.
- 1.4.7 Спорт аялалыг хөгжүүлнэ.
- 1.4.8 Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, холбоодууд, сайн дурын дэмжигч, зүтгэлтнүүдийн санал санаачилгыг нэгтгэж, хамтран ажиллана.

1.5 Хөдөлмөр эрхлэлт

- 1.5.1 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, тогтвортой, шинэ ажлын байрыг бий болгож ажилгүйдлийн түвшинг бууруулна

- 1.5.2 Бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын томоохон төслүүд болон хоршоо, жижиг дунд үйлвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлж, шинэ ажлын байрууд бий болгоно.
- 1.5.3 Гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд хөдөлмөр эрхлэгчдийн мэргэжлийн ур чадварыг сайжруулах, ур чадвартай ажилтан бэлтгэх, урт богино хугацааны сургалтад иргэдийг хамруулна..
- 1.5.4 Сумынхаа эдийн засгийн бүтцийг бэхжүүлж, өөрийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хэрэглэх, иргэд, өрхийн үйлдвэр эрхлэгчдийг хоршосгоороо дамжуулан, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ худалдаалах тогтвортой сүлжээг бий болгоно.
- 1.5.5 Батсүмбэрт үйлдвэрлэв" худалдаа үйлчилгээний агентуудыг нэмэгдүүлнэ.
- 1.5.6 Дутагдалтай байгаа хүний нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх зорилгоор төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.6 Орон сууцнуудыг барих

- 1.7.1 Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй ипотекийн зээлийн хүртээмж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.
- 1.7.2 Сумандаа төрийн албан хаагчдын орон сууц барих, шинэ технологийн дагуу шинэ болон хэрэгжиж буй төслүүдийг гүйцэтгүүлэн хэрэгжүүлж, хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцны зээлд хамруулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 1.7.3 Инженерийн хангамжтай хувийн сууцны хангамжийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.
- 1.7.4 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилга, байгууламж, байруудыг дахин төлөвлөлтөд хамруулна.

1.8 Хүн ам, нийгмийн бүлэг бүрд чиглэсэн хөгжлийн боллого

Хүүхэд

- 1.8.1 Хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, нийгмийн амьдралд оролцох, хамгаалуулах эрхийг хангахад эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.8.2 Насанд хүрсэн иргэн бүр хүүхэд хамгаалагч байхад чиглэсэн хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт хандлагыг өөрчлөх нөлөөллийн ажлуудыг өргөжүүлж, хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Өсвөр үе ба оюутнууд

- 1.8.3 Сумын Засаг даргын дэргэдэх оюутны зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

- 1.8.4 Дотоод, гадаадын их дээд сургуульд тэтгэлгээр суралцах оюутны тоог нэмэгдүүлнэ.

Залуучууд

- 1.8.5 Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүй, хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан “Залуус” хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.8.6 Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжиж хөгжүүлнэ.

Гэр бүл

- 1.8.7 Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, гэр бүлд ээлтэй хөгжил хамгааллын бодлого, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.8.8 Гэр бүлийн хүчирхийллийг зогсооход чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг нэмэгдүүлнэ.

Ахмад настан

4117144522

НУМ 0061-2060164

- 1.8.9 Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, ахмад настны амралтын болон өргөөтэй болгох.
- 1.8.10 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, туршлагыг нь түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Ахмадын зөвлөх үйлчилгээ”-г нэмэгдүүлнэ.

Эхчүүд эмэгтэйчүүд

- 1.8.11 Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын уялдааг хангах стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, бүх нийтэд жендэрийн боловсрол олгох нөлөөллийн ажлыг тогтмолжуулна.
- 1.8.12 Хүүхдээ асарч буй ээжүүдэд зориулсан нэмэлт орлого олох, бизнесээ өргөжүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжсэн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

Эрэгтэйчүүд

- 1.8.13 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл зөв дадал хэвшил эзэмшүүлэх нөлөөллийн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх аймгийн хөтөлбөрийг дагаж хамтран ажиллана.
- 1.8.14 Эмэгтэй эрэгтэй хүмүүсийн дундаж наслалтын эерүү багасгуулах, эрүүл арга хэмжээг авч хэрэгжүүлнэх ажлыг эрчимжүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд

- 1.8.15 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийн болон мэдээллийн хүртээмжийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн бүх харилцаанд бүрэн дүүрэн, эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлнэ.

- 1.8.16** Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна.
- 1.8.17** Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг эрчимжүүлнэ.

Малчид, тариаланчид

- 1.8.18** Малчдын орлогыг нэмэгдүүлэх, зудаас урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн арга хэмжээ авах талаар залуу малчдад туршлага түгээх
- 1.8.19** Малчид, тариаланчид, хөдөө орон нутгийн иргэдэд зориулсан элсын зайн эрүүл мэндийн оношилгоо, үйлчилгээний шинэ технологийг нэвтрүүлж, эмнэлгийн тусламж үйлчилгээг түргэн шуурхай үзүүлнэ.

4117144522
НЮА0064 9060464

Ажилтан

- 1.8.20** Ажилтныг шударга үнэлэх, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөр эрхлэгчдэд тулгарч буй нийтлэг асуудлуудыг шийдвэрлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

**Амьжиргааны баталгаажих түшингээс доогуур
орлоготой иргэд**

- 1.8.21** "Халамжаас-Хөдөлмөрт" бодлогыг хэрэгжүүлж амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшинг тууштай бууруулна.
- 1.8.22** Зорилтот бүлгийн хэрэгцээнд нийцүүлж, бие даан амьдрах, амжиргааг дэмжих "Гэр" төсөл хэрэгжүүлнэ.

Иргэн бүрт

- 1.8.23** Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, албан бус салбарт хөдөлмөр эрхэлж байгаа иргэд, малчид, өрхийн болон хувиараа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлнэ.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО

2.1. Эдийн засаг, төсөв санхүү

- 2.1.1. Эдийн засгийн чөлөөт бүс, үйлдвэр технологийн парк байгуулах ажилд сумын зүгээс идэвхитэй оролцох, орон нутгийн бодлогоор дэмжиж, тус бүсэд байгуулагдах худалдаа, үйлчилгээ, хөнгөн үйлдвэрийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалт татах замаар хэрэгжүүлнэ.
- 2.1.2. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, боловсруулах үйлдвэрийн томсохон бүтээн байгуулалтын төслийг дэмжин, сумын оролцоог хангаж хамтран ажиллана. .
- 2.1.3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийг нийгэмд өгөөжтэй, хүртээмжтэй, эдийн засгийн ач холбогдолтой зэргээр эрэмбэлж, санхүүжүүлэх бодлого баримтална.
- 2.1.4. Хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд орон нутагт шинээр байгуулагдсан, шилжин ирэх аж ахуйн нэгжүүдийг татварын уян хатан бодлогоор дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлэх, татварын бааз суурийг өргөгөх бодлого хэрэгжүүлнэ.
- 2.1.5. Татварын бааз суурийг өргөтгөх замаар хоршоолол, бүсчилсэн хөгжлийг дэмжих чиглэлээр хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. .
- 2.1.6. Төсвийн талаархи хууль тогтоомжийг бүх шатанд хэрэгжүүлж, төсвийн үр ашигтай байдалд тавих хяналтыг боловсронгуй болгоно.

ГУРАД: ХҮНД ХӨДӨӨ АЖ АХУЙН ТОГТООМЖИЙН ХӨГЖИЛТ

3.1 Хөдөө аж ахуйн тогтвортой байдлыг

- 3.1.1 Газар тариалан, мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, аймгийн хэмжээний гол үйлдвэрлэгч сум болж чадсан давуу тал, нөөцдөө тулгуурлан, нийслэл болон төвийн бүсийн зах зээлийн интграцид манлайлан оролцоно.
- 3.1.2 Орон нутгийн онцлогт тохирсон нүүдлийн болон эрчимжсэн мал аж ахуйн зохистой бодлогыг хэрэгжүүлнэ.
- 3.1.3 Малын үүлдэр угсааг нутгийн шилмэл омог, үүлдрээр сайжруулж, цэвэр эрлийз малын тоог нэмэгдүүлнэ.
- 3.1.4 Тодорхой бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэн, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 3.1.5 Гахай, тахиа, өндөг, зөгийн аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- 3.1.6 Малын тэжээлийн үйлдвэрийг бүсчлэн байгуулах бодлого хэрэгжүүлж, өвс тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд хувийн хэвшилтэй хамтран ажиллана.
- 3.1.7 Хөдөө аж ахуйн салбарт ажиллагсадын хөдөлмөрийг хөнгөвчлөх, бүтээмжийг нэмэгдүүлэх тоног төхөөрөмжийг нэвтрүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- 3.1.8 Мал, амьтныг эмчлэх, гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг чанартай хийж, дархлаажуулалт, шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар "Гоц халдварт өвчингүй тайван бүс"-ийг баталгаажуулна.

- 3.1.9 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн 4 улиралд бэлтгэн нийлүүлэх нэгдсэн тогтолцоог төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, орчин үеийн агуулах зоорийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 3.1.10 Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэн тариалангийн талбайн ашиглалтыг 80-аас доошгүй хувьд хүргэж, салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
- 3.1.11 Усалгаатай газар тариаланг дэмжиж, усалтын системүүдийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлүүлж, ашиглалтыг сайжруулан, засвар шинэчлэлийг шат дараатайгаар хэрэгжүүлж, орон нутгийн онцлогт зохицсон эрчимжсэн агро-технологи нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн хэмжээг 20 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.
- 3.1.12 Тариалангийн талбайг хашаажуулах ажлыг үргэлжлүүлж, ойн зурвас байгуулах зэргээр хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, үржил шимийг сайжруулах арга хэмжээг төр хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- 3.1.13 Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл, өрхийн тариалан эрхлэлтийг дэмжин шинэ техник, технологи нэвтрүүлэн, газар тариаланг механикуулах ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.
- 3.1.14 Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын хөрөнгийн хангана
- 3.1.15 Тэжээлийн таримлын нэр төрөл, тариалалтыг нэмэгдүүлж, тэжээлийн тариалалтаар аймагтаа тэргүүлсэн амжилтаа бататган, аймгийн хэмжээний малын тэжээлийн 10-аас доошгүй хувийг үйлдвэрлэнэ.
- 3.1.16 "Хүнсний хувьсгал" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, гол нэр төрлийн тодорхой хувийг дотоодын үйлдвэрлэлийн бодлогоор дэмжиж ажиллана.

3.2. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөгөөт шинэ хөрөнгийн хөдөлгөөн

- 3.2.1 Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлтийн хүрээнд Хоршооны хөгжлийн талаар бий болгосон бүтэц арга зүй, туршлагаа "Шинэ хоршоо" хөдөлгөөнтэй хослуулан боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.
- 3.2.2 "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн стратеги төлөвлөгөө"-нд тусган хэрэгжүүлж буй дундын хоршоо, гэрээт менежментийн үйл ажиллагааг эрчимжүүлж, сумдын эдийн засгийн бүтцийг улам сайжруулна.
- 3.2.3 Гадаад орнуудын хоршооны сайн туршлагыг дэлгэрүүлж, хоршоодын гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 3.2.4 Хоршоодод хэрэгжүүлж буй хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмж нэмэгдүүлэхэд чиглэсэн хонь хяргах, цагаан идээ боловсруулах, өвс хадлан тэжээл бэлтгэх, өрхийн тариалангийн техникуудийг хөдөө аж ахуйн салбарт улам бүр нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг үргэлжүүлнэ.
- 3.2.5 Хоршоодод олгож буй хамтын хариуцлагын хөнгөлөлттэй зээл олгох хөтөлбөрт хоршоодыг хамруулах, зээлийн ашиглалт, өгөөжийг нэмэгдүүлэх, хоршоодын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн мэргэжил, арга зүйн сургалт, зөвлөгөөг нэмэгдүүлж хоршоодын үйл ажиллагааг тогтмолжуулах, үр ашигтай байлгах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- 3.1.9 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг жилийн 4 улиралд бэлтгэн нийлүүлэх нэгдсэн тогтолцоог төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлж, орчин үеийн агуулах зоорийн аж ахуйг хөгжүүлнэ.
- 3.1.10 Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэн тариалангийн талбайн ашиглалтыг 80-аас доошгүй хувьд хүргэж, салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.
- 3.1.11 Усалгаатай газар тариаланг дэмжиж, усалтын системүүдийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлүүлж, ашиглалтыг сайжруулан, засвар шинэчлэлийг шат дараатайгаар хэрэгжүүлж, орон нутгийн онцлогт зохицсон эрчимжсэн агро-технологи нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн хэмжээг 20 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.
- 3.1.12 Тариалангийн талбайг хашаажуулах ажлыг үргэлжлүүлж, ойн зурвас байгуулах зэргээр хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, үржил шимийг сайжруулах арга хэмжээг төр хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- 3.1.13 Хамгаалагдсан хөрсний үйлдвэрлэл, өрхийн тариалан эрхлэлтийг дэмжин шинэ техник, технологи нэвтрүүлэн, газар тариаланг механикжуулах ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.
- 3.1.14 Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дотоодын туралж агуулах хангана.
- 3.1.15 Тэжээлийн таримлын нэр төрөл, тариалалтыг нэмэгдүүлж, тэжээлийн тариалалтаар аймагтаа тэргүүлсэн амжилтаа бататган, аймгийн хэмжээний малын тэжээлийн 10-аас доошгүй хувийг үйлдвэрлэнэ.
- 3.1.16 "Хүнсний хувьсгал" хөтөлбөрийг хэрэгжүүлэн, гол нэр төрлийн тодорхой хувийг дотоодын үйлдвэрлэлийн бодлогоор дэмжиж ажиллана.


3.2. Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт "Шинэ хоршоо" хөдөлгөөн

- 3.2.1 Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлтийн хүрээнд Хоршооны хөгжлийн талаар бий болгосон бүтэц арга зүй, туршлагаа "Шинэ хоршоо" хөдөлгөөнтэй хослуулан боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.
- 3.2.2 "Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн стратеги төлөвлөгөө"-нд тусган хэрэгжүүлж буй дундын хоршоо, гэрээт менежментийн үйл ажиллагааг эрчимжүүлж, сумдын эдийн засгийн бүтцийг улам сайжруулна.
- 3.2.3 Гадаад орнуудын хоршооны сайн туршлагыг дэлгэрүүлж, хоршоодын гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 3.2.4 Хоршоодод хэрэгжүүлж буй хөдөлмөр хөнгөвчлөх, бүтээмж нэмэгдүүлэхэд чиглэсэн хонь хяргах, цагаан идээ боловсруулах, өвс хадлан тэжээл бэлтгэх, өрхийн тариалангийн техникүүдийг хөдөө аж ахуйн салбарт улам бүр нэвтрүүлэх төсөл, хөтөлбөрийг үргэлжүүлнэ.
- 3.2.5 Хоршоодод олгож буй хамтын хариуцлагын хөнгөлөлттэй зээл олгох хөтөлбөрт хоршоодыг хамруулах, зээлийн ашиглалт, өгөөжийг нэмэгдүүлэх, хоршоодын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн мэргэжил, арга зүйн сургалт, зөвлөгөөг нэмэгдүүлж хоршоодын үйл ажиллагааг тогтмолжуулах, үр ашигтай байлгах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- 3.2.6 Бэлчээрийн мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийн хугацааг богиносгож хонь, бяруу бордох болон мах, сүүний эрчимжсэн үхрийн аж ахуйн мах боловсруулах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах зэрэг орон нутгаар, хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

3.3 Нийлүүлэгчийн зэрэгцээ үйлдвэрлэлч аймаг

- 3.3.1 Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн стратеги төлөвлөгөө, түүний хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийг гадаад, дотоод хөрөнгө оруулагчидтай хамтран хэрэгжүүлнэ.
- 3.3.2 Газар зүйн заалттай болон орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх талаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачидтай хамтарч ажиллана.
- 3.3.3 Бүтээгдэхүүн сурталчлах, борлуулах үзэсгэлэн худалдааг дотоод гадаадад олон хэлбэрээр зохион байгуулна.



ДӨРӨВ. НОГООН ЭДИЙН ЗАСАГ БА АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО

4.1. Төрөлжсөн аялал жуулчлал

- 4.1.1. Сумын аялал жуулчлалыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлж, ашигтай байршил, байгалийн өгөгдөл, түүхэн дурсгалт газрууд зэрэг давуу талдаа түшиглэн аялал жуулчлалыг сумынхаа эдийн засгийг тэлэх суурь салбар болгон хөгжүүлэх бодлогыг дэмжиж ажиллана.
- 4.1.2. Орон нутгийн онцлог болон нутгийн иргэдэд, 4 улирлын аялал жуулчлалын хөтөлбөрүүдийг бий болгож, жуулчид хүлээн авах таатай орчин бүрдүүлнэ.
- 4.1.3. Сумаа аялал жуулчлалын төв болгон хөгжүүлэх ажлыг зохион байгуулна.

4.2. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл

- 4.2.1 Аялал жуулчлалыг иргэдийн орлогыг нэмэгдүүлэх нэг эх үүсвэр болгож, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, нийтийн хоол, соёлын бүтээлч үйлвэрлэл, театр, музей, номын сан, үндэсний спорттой нягт уялдуулж хөгжүүлнэ.
- 4.2.2 Дотоодын аялал жуулчлалд зориулсан соёлын хөтөлбөр, худалдаа үйлчилгээг өргөжүүлнэ.

- 5.1.1 Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудын идэвх оролцоотойгоор төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг тодорхой хувиар нэмэгдүүлнэ.

- 5.1.2 Ойн хортон шавж, өвчний тархалтын судалгаа, тэмцлийн ажил зохион байгуулах, ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг нэмэгдүүлнэ.
- 5.1.3 Ус цаг уурын ажиглалтын болон орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлээс урьдчилан мэдээллэх сэрэмжлүүлэх чадавхийг бэхжүүлж байгалийн гамшигт үзэгдлийн эрсдэлийг бууруулж, зориудаар хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаанд технологийн шинэчлэл хийнэ.
- 5.1.4 Цөлжилт, хөрсний доройтол, бохирдлыг хязгаарлаж, бэлчээр хөнөөгч мэрэгч амьтадтай байгаль орчинд ээлтэй аргаар тэмцэх, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.1.5 Ховор, нэн ховор ан амьтдыг тархац нутгаар нь хамгаалж, нөхөн үржүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулж, биологийн олон янз байдлын удмын санг хамгаалан, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэн, хомсдолоос сэргийлж, ашиглалтын нөөц бүрдүүлнэ. 4117144522
НЮА0064 9060464
- 5.1.6 Ховор, нэн ховор, ашиглалтад өртөмтгий ургамлын нөөцийг тогоох, ховордлын шалтгааныг тогтоож хамгаалах арга хэмжээг авна.
- 5.1.7 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилах, ачих, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний менежментийг сайжруулна.
- 5.1.8 Хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор сумын төв, суурин газрын гэр хорооллын айл өрх болон аялал жуулчлалын баазуудад нүхэн жорлонгийн стандартыг хангуулах арга хэмжээ авч, "Эко жорлон" арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.2.1 Усны хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ус ашиглалтын нөхцөл боломжийг гарган тавьж усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлж, усны нөөц бохирдож, хомсдолоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.2.2 Сум суурингийн ундны усны худагт ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулж, хүн амыг цэвэр усаар хангана.
- 5.2.3 Хараа голыг бохирдуулж буй хүчин зүйлсийн нөлөөллийг зогсоож, цэвэршүүлэх, усны нөөц сав газрыг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх ажлыг Хараа голын сав газрын захиргаатай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. ХОТ ХӨДӨӨГИЙН ТЭНЦВЭРТ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6.1 Хөгжлийг тэтгэсэн дэд бүтэц-Сумын хөгжил

- 6.1.1 "Сумын төвийн хөгжил-инженерийн дэд бүтцийн хангамж" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

- 6.1.2 Хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан сумын төв суурин газарт явган хүний болон дугуйн зам, биеийн тамирын талбай, хүүхдийн тоглоомын талбай, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, тохилог орчныг бүрдүүлнэ.
- 6.1.3 Төсөвт байгууллагуудын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засвар хийх ажлуудыг улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламж, төсөл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.
- 6.1.4 Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барих, шинэчлэх, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 6.1.5 Хот суурины үерийн далан, суваг борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу санхүүжилийг шийдвэрлүүлэн үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 6.1.6 Газрын талаар баримтлах аймгийн бодлогыг хэрэгжүүлэн нэн тэргүүнд сумын иргэд, аж ахуйн нэгжид газар өмчлүүлэх, эзэмшүүлэх бодлого баримталж ажиллана.
- 6.1.7 Мэдээлэл, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөж, техник технологийг нэвтрүүлнэ.

6.2. Зам дагасан хөгжил

- 6.2.1. Сум баг хоорондын улсын чанартай авто замтай хатуу хучилттай замаар холбогдох зураглалыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.
- 6.2.2. Сумын төв доторх авто замыг нэмэгдүүлнэ.
- 6.2.3. Авто зам, гүүрийн байгууламжид үнэлгээ хийж, орон нутгийн чанартай хатуу хучилттай авто зам, гүүрийн их засвар шинэчлэлтийг шат дараатай хийнэ.
- 6.2.4. Сумын төв доторх 2,4 км хатуу хучилттай автозам, гэрэлтүүлгийн ажлыг эхлүүлэх
- 6.2.5. Сумын төвийн хэсгийг үерээс хамгаалах, далан сувгийн ажлыг эхлүүлэх талаар холбогдох газарт хандах

ДОЛОО. ИРГЭДИЙН ОРОЛЦООНД ТУЛГУУРЛАСАН ЦАХИМ ЗАСАЛЛАЛ

7.1. Хүний эрх ба амар тайван, аюулгүй орчин

- 7.1.1 Хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 7.1.2 Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлыг хангана.
- 7.1.3 Төрийн архивын цахим үйлчилгээг байгууллага, иргэдэд шуурхай хүргэж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 7.1.4 Иргэд олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх замаар нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангана.

- 7.1.5 Дэвшилтэт технологид суурилсан камерын нэгдсэн системийг нэвтрүүлж, "НОГООН БҮС"-ийг бий болгоно.
- 7.1.6 Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах стандартад нийцсэн түр хамгаалах байртай болгоно.
- 6.1.8 Авто зам, гүүрийн байгууламжид үнэлгээ хийж, орон нутгийн чанартай хатуу хучилттай авто зам, гүүрийн их засвар шинэчлэлтийг шат дараатай хийнэ.

7.2 хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа

- 7.2.1 Төрийн захиргааны албан хаагчдын тоон өсөлтийн зохистой харьцааг тогтооно.
- 7.2.2 Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.
- 7.2.3 Багш, эмч, төрийн албан хаагчдын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, ажлын хариуцлага, үр дүнг сайжруулна.
- 7.2.4 Төрийн албан хаагчдын тасралтгүй сурч хөгжих тогтолцоог бүрдүүлэн, төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлнэ.
- 7.2.5 Төрийн албан хаагч нь улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.
- 7.2.6 Төрийн албан хаагчдыг татварын хөнгөлөлтийн зургаа хүртэлх сая төгрөгийг орон байрны урьдчилгаанд тооцуулах, батлан даах боломжийг бүрдүүлнэ.

7.3. Цахим засаглал ба иргэдэд ойр үйлчилгээ

- 7.3.1 Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 7.3.2 Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.
- 7.3.3 Төр, иргэн, хувийн хэвшил цахимаар мэдээлэл солилцох дэд бүтцийг сайжруулна.
- 7.3.4 Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- 7.3.5 Мэдээлэл харилцаа холбоо, хиймэл оюун ухаан, шинэ технологийг уул уурхай, боловсруулах аж үйлдвэр, эрчим хүч, зам тээвэр, логистик, эрүүл мэнд, хөдөө аж ахуй зэрэг бүх салбарт өргөнөөр нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.
- 7.3.6 "Старлинк" зэрэг нам орбитын хиймэл дагуулын үйлчилгээ үзүүлэгчдийг дэмжинэ.
- 7.3.7 Төр, хувийн хэвшил, судалгааны байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжинэ.

- 7.3.8 Аливаа контентын жинхэнэ эсвэл хиймэл оюун ухаанаар бүтээгдсэн эсэхийг тодорхойлох, байгууллагын болон иргэдийн нэр хүндэд халдах аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх системийг бүрдүүлнэ.
- 7.3.9 Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, газрын бүртгэл, харилцаанд "блокчейн" технологийг ашиглан маргааныг бууруулна.

